

ГХБХБГ-ын даргын 2017 оны 03 дугаар сарын
20 өдрийн 21 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ЛАБОРАТОРИЙН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Барилгын материалын лаборатори нь /цаашид Лаборатори гэх/ барилгын материал, хийц бүтээц, түүхий эдийн үндсэн шинж чанарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, норм нормативийн баримт бичгийн шаардлагын дагуу сорилт шинжилгээ гүйцэтгэх үндсэн үүрэг бүхий Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын /цаашид ГХБХБГ гэх/ нэгж юм.
- 1.2. Энэхүү дүрмээр лабораторийн үйл ажиллагааны үндсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зарчим, удирдлага, бүтэц зохион байгуулалтын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.3. Лаборатори нь үйл ажиллагаандaa Барилгын тухай хууль болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандарт, норм норматив, лабораторийн чанарын гарын авлагыг удирдлага болгоно.
- 1.4. Лаборатори нь үйл ажиллагаандaa төрийн албаны ёс зүй, үнэнч шударга байдлыг эрхэмлэж, хууль дээдлэх, гадны аливаа нөлөөллөөс ангид, хараат бусаар ажиллах зарчмыг баримтална.
- 1.5. Лаборатори нь сорилтын үр дүнг бие даасан, хараат бусаар гаргана.
- 1.6. Сорилт, шинжилгээний үр дүнг баталгаажуулах албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

- 2.1. Лаборатори нь эрхлэгч, шинжээчдээс бүрдэнэ.
- 2.2. Лабораторийн үйл ажиллагааг эрхлэгч удирдах ба түүнийг газрын дарга томилж, чөлөөлнө. Эрхлэгч нь мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан, дадлага туршлагатай хүн байна.
- 2.3. Эрхлэгч нь лабораторийн чанарын гарын авлага болон ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг удирдлага болгон ажиллана.

2.4. Эрхлэгч нь албан тушаалын эрхээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийг чанд мөрдөж, албан үүрэгтэй холбоотой аливаа үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилгүй, үнэнч шударга, ёс зүйтэй ажиллаж, нийтийн эрх ашгийг эрхэмлэнэ.

2.5. Лаборатори нь иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийн дагуу ирүүлсэн дээжинд сорилт, шинжилгээг стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

2.6. Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалттай барилга байгууламжийн угсралт, их засварын ажлуудад лабораторийн хяналтыг хэрэгжүүлнэ.

2.7. Харилцагч, үйлчлүүлэгчийн мэдээлэл, үр дүнгийн нууцлалыг хангах, тэдний санал хүсэлтийг хүлээн авах, засаж запруулах, хариу мэдээлэх зэргээр эргэх холбоотой ажиллана.

2.8. Лабораторийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Газрын даргаар батлуулан, гүйцэтгэлийг хугацаанд нь тайлagnана.

2.9. Сорилтын үр дүнд анализ хийж, үр дүн, үйл ажиллагааг үргэлжид сайжруулах арга хэмжээг авах, мэдээллийн сан үүсгэж баяжуулж ажиллана.

2.10. Лабораторид шинжлэх барилгын материал, хийц бүтээц, түүхий эдийн шинжилгээний үнийн тарифыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын тушаалаар батлуулан мөрдөж ажиллана.

Гурав. Лабораторийн эрхлэгч, шинжээч

3.1. Эрхлэгч, шинжээчид нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг Үүргийг газрын даргатай байгуулсан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

3.2. Эрхлэгч, шинжээчид нь чанарын удирдлагын тогтолцооны үр нөлөөтэй байдлыг үргэлжид сайжруулах, стандартад нийцэж ажиллана.

3.3. Эрхлэгч, шинжээчид нь Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, лабораторийн үйл ажиллагааны журмыг мөрдөж, эрх үүргийг хэрэгжүүлж ажиллана.

3.4. Эрхлэгч, шинжээчид нь лабораторийн багаж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хариуцна.

Дөрөв. Лабораторийн үйл ажиллагаанд хориглох зүйл

4.1.Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг зөрчих, хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслэлийг бүрэн хэрэглэхгүй байх, тоног төхөөрөмжийн ашиглалтын зааварчилгааг зөрчих

4.2.Лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлийг эрхлэгчийн зөвшөөрөлгүйгээр ажлын байрнаас гаргах, ажил үүрэгтэй холбоогүй ажил үүрэгт ашиглах

4.3.Сорилт шинжилгээний дүн эцэслэн гараагүй байхад үйлчлүүлэгч, харилцагчид албан бусаар үр дүнг мэдэгдэх

4.4.Хууль тогтоомжоор хориглосон бусад үйл ажиллагаа

Тав. Бусад

5.1.Энэ дүрмээр зохицуулагдаагүй асуудлыг бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

5.2.Хууль тогтоомж, Газрын дүрмийн өөрчлөлт, зайлшгүй хэрэгцээ шаардлага зэргийг үндэслэн тус журамд нэмэлт, өөрчлөлтийг Газрын даргын тушаалаар оруулж болно.

---оо---